"ЭНИЧ АУДИТ" ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Сөүл гудамж, Моодун цамхаг, 11/1-р байр, 502 тоот
Утас/Факс: 70002115, 91918420
И-мэйл: enichaudit@gmail.com

_____ № _____

танай _____ -ны № _____ -т

ДАЛАНЗАДГАД КАПИТАЛ ББСБ,
ХХК-ИЙН УДИРДЛАГАД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид 2024 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн Даланзадгад Капитал ББСБ, ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Даланзадгад Капитал ББСБ, ХХК-ийн 2024 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээг Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв толилуулж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм-ийг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байх ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

АОУС–ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандалгыг баримтлан ажилладаг.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үзэж аудиторын тайландаа тодорхойлдог.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайлан нь Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчид зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно

“ЭНИЧ АУДИТ” ХХК-ийн
Захирал

Г.Чинтуяа (МНБ, Аудитор)

2025 оны 02 сарын 10

БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үүсгэн байгуулах шийдвэр	“Даланзадгад Капитал ББСБ”, ХХК нь 2014 оны 01-р сарын 01-ний өдрийн 1/01 тоот үүсгэн байгуулагчийн тоот шийдвэрийн дагуу Зээлийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр Банк бус санхүүгийн байгууллага, хязгаарлагдмал хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.
Гэрчилгээ ба лиценз	2013 оны 11-р сарын 08–ны өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 3623521 тоот регистр, 1115001001 тоот бүртгэлийн дугаар бүхий хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 000064541 тоот гэрчилгээг олгосон. 2014 оны 2 сарын 26-ны өдрийн СЗХ-ны 51-р тогтоолоор ТЗ 101/335 тоот Банк бус санхүүгийн ажиллагаа эрхлэх Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон.
Хаяг байршил	Бүртгэлтэй хаяг нь: Өмнөговь, Даланзадгад, 3-р баг, Далан
Холбоо барих утас	99810404
Хувь нийлүүлсэн хөрөнгө	831,214,000.00 төгрөг
Үйл ажиллагааны чиглэл	6492 – Зээлийн үйл ажиллагаа 6612 – Гадаад валютын арилжаа



"ДАЛАНЗАДГАД КАПИТАЛ ББСБ" ХХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31

(төгрөг)

	тэмдэглэгээ	2023	2024
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	8,252,215.65	30,493,680.52
Зээл (цэврээр)	4	1,326,787,945.77	1,356,446,137.76
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	5	176,261,621.35	362,752,342.42
Бусад авлага	6	48,714,699.01	155,251,080.46
Урьдчилж төлсөн зардал	7	52,712,000.00	-
Нийт эргэлтийн хөрөнгө		**1,612,728,481.78**	**1,904,943,241.16**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	8	32,135,486.75	43,149,829.30
Биет бус хөрөнгө	9	-	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө		**32,135,486.75**	**43,149,829.30**
Нийт хөрөнгийн дүн		**1,644,863,968.53**	**1,948,093,070.46**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ			
Богино хугацаат өр төлбөр			
Тайлант үеийн татварын өглөг	**10**	37,992,007.65	35,819,287.93
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**37,992,007.65**	**35,819,287.93**
Урт хугацаат өр төлбөр		-	
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	
Нийт өр төлбөрийн дүн		**37,992,007.65**	**35,819,287.93**
Өөрийн хөрөнгө			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	11	831,214,000.00	831,214,000.00
Нэмж төлөгдсөн капитал	11	14,255,175.75	14,255,175.75
Хуримтлагдсан ашиг	11	**761,402,785.13**	**1,066,804,603.78**
Тайлант үеийн ашиг	11	317,495,141.15	305,401,818.65
Өмнөх үеийн ашиг	11	443,907,643.98	761,402,785.13
Өөрийн хөрөнгийн дүн		**1,606,871,960.88**	**1,912,273,779.53**
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн		**1,644,863,968.53**	**1,948,093,067.46**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно



"ДАЛАНЗАДГАД КАПИТАЛ ББСБ" ХХК
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31

(төгрөг)

Үзүүлэлт	тэмдэглэгээ	2023	2024
Хүүгийн орлого		**493,941,040.78**	**500,166,016.86**
Банканд байршуулсан хөрөнгийн хүү	12	428,571.98	204,075.10
Зээлийн хүү	13	493,512,468.80	499,961,941.76
Хүүгийн зардал	**13**	13,075,550.00	**-**
Хүүгийн цэвэр орлого		**480,865,490.78**	**500,166,016.86**
Эрсдэлийн сангийн зардал	15	17,547,325.30	15,851,523.50
Эрсдлийн сангийн дараах цэвэр орлого		**463,318,165.48**	**484,314,493.36**
Хүүгийн бус орлого		**8,314,576.42**	**3,988,963.33**
Гадаад валютын арилжааны орлого	**17**		56,200.00
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	16	639,801.42	78,763.33
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	18	7,674,775.00	3,854,000.00
Бусад орлого, олз	19	**1,302,906.99**	**3,351,455.80**
Хүүгийн бус зардал		**130,578,617.64**	**177,042,526.31**
Арилжааны зардал	20	56,380.00	-
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	20	240,810.04	110,637.70
Хураамж, шимтгэлийн зардал	21	764,059.34	553,983.82
Үйл ажиллагааны бусад зардал	22	129,517,368.26	176,377,904.79
Бусад зардал, гарз	**23**	**8,172,620.00**	**6,075,360.00**
Татварын өмнөх ашиг/алдагдал		**334,184,411.25**	**308,537,026.18**
Орлогын албан татварын зардал	24	16,689,270.10	3,135,207.53
Цэвэр ашиг		**317,495,141.15**	**305,401,818.65**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно

"ДАЛАНЗАДГАД КАПИТАЛ ББСБ" ХХК
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31

(төгрөг)

	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	**831,214,000.00**	**14,255,175.75**	**443,907,643.98**	**1,289,376,819.73**
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-		317,495,141.15	**317,495,141.15**
2023 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	**831,214,000.00**	**14,255,175.75**	**761,402,785.13**	**1,606,871,960.88**
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-		305,401,819	**305,401,818.65**
2024 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	**831,214,000.00**	**14,255,175.75**	**1,066,804,603.78**	**1,912,273,779.53**

УЛААНБААТАР ХОТ
ЭНИЧ-АУДИТ
ХХК
АТА13161 2811391

"ДАЛАНЗАДГАД КАПИТАЛ ББСБ" ХХК
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31

(төгрөг)

Үзүүлэлт	2023	2024
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	1,574,401,367.86	1,185,037,276.46
Харилцах дансны хүүгийн орлого	428,571.98	
Гадаад валютын арилжааны орлого	342,611.38	
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	876,575.00	
Бусад		358,400.73
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**1,576,049,126.22**	**1,185,395,677.19**
Олгосон зээл	1,173,872,429.38	726,275,550.07
Ажиллагсдад олгосон	72,349,796.00	100,895,645.58
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	19,698,326.64	71,684,573.62
Ашиглалтын зардалд төлсөн		11,771,726.53
Бусад	333,751,373.29	252,526,316.52
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**1,599,671,925.31**	**1,163,153,812.32**
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(23,622,799.09)**	**22,241,864.87**
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	**-**	
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,399,800.00	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	**9,399,800.00**	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(9,399,800.00)**	
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бусад	113,163,521.67	
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	**113,163,521.67**	
Банк, санх.байгууллага, төсөл,хөтөлбөрийн зээлд төлсөн	142,000,000.00	
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**142,000,000.00**	**-**
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(28,836,478.33)**	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(61,859,077.42)**	**22,241,864.87**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**70,111,293.07**	**8,251,815.65**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**8,252,215.65**	**30,493,680.52**

УЛААНБААТАР ХОТ
ЭНИЧ-АУДИТ
ХХК
АТА13161 2811391